

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг:

“14.6. Энэ хуулийн 4.1-д<sup>1</sup> заасан этгээдийн хувь хүний орлогын албан татвар төлөлтийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 07 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

---

<sup>1</sup> 4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт<sup>2</sup> “энэ” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

---

<sup>2</sup> Татварын ерөнхий хуулийн 13.1.Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглоно.